



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2023.03.14 № 01/484
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд “Дотоодын цэргийн тухай хуулийн 36.3-т заасан хугацаа нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэнд хамаарахгүй”, мөн хуулийн 6 дугаар зүйлд “Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж, Дотоодын цэргийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Энэ хуулийг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж тус тус заасан тул 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө дотоодын цэргээс тэтгэвэр тогтоолгосон хүний цэргийн тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй болно.

Иймд тус газрын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/469 дүгээр албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийн 1.3-т заасан “...2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс өмнө дотоодын цэргээс тэтгэвэр тогтоолгосон хүний цэргийн тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй болно.” гэснийг “...2017 оны 09 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө дотоодын цэргээс тэтгэвэр тогтоолгосон хүний цэргийн тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй, харин мөн өдөр буюу түүнээс хойш цэргийн тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч нь алба хаасан хугацаагаа нэмэгдүүлэн тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд Дотоодын цэргийн байгууллагад алба хаасан хугацааг шинэчлэн тооцсон тодорхойлолт, архивын лавлагааг үндэслэн тэтгэврийн хэмжээг нь өөрчлөн тогтоож, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан өөрчлөгдсөн тэтгэврийг олгоно.” гэж залруулж байгаа тул хэрэгжилтийг зохион байгуулна уу.

Хавсралт ¹⁵ хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2023.03.13 № 01/469
танай _____-ны № _____-т

АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газраас тус тус ирүүлсэн чиглэлийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар Цагдаагийн албаны тухай тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийг “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно” гэж өөрчлөн, 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр баталсан.

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” 01/58 дугаар албан бичгээр ирүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлийг тус газрын 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/298 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Уг зөвлөмжийн 3.3-т “Цагдаагийн алба хаагчийн цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан, хүүхдээ асрах чөлөөтэй байсан, цагдаагийн байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцсан хугацаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасанд хамаарахгүй тул уг алба хаасан 1 жилийг нэмэгдүүлэхгүй хэвээр нь тооцож цэргийн тэтгэвэр тогтоох” талаар дурдсан.

Цагдаагийн ерөнхий газраас 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн “Тодруулга, чиглэл хүргүүлэх тухай” 01/118 дугаар албан бичгээр цагдаагийн болон дотоодын цэргийн алба хаагчийн цэргийн алба хаасан хугацааг хэрхэн тооцох талаар нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нэмэлт тодруулга, чиглэл ирүүлсэн байна. Үүнд:

1.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн цол олгогдон цагдаагийн байгууллагын захиалгаар, эрх бүхий байгууллагын тушаал шийдвэрээр гадаад, дотоодын академи, их, дээд сургууль, коллеж болон мэргэжил олгох, дээшлүүлэх курст суралцсан, Дотоод хэргийн их сургууль (өмнө нь НАХЯ-ны

1523070491

харьяанд Цэргийн сургууль, Цагдаагийн дээд сургууль, Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль зэрэг нэртэй байсан)-д цолтойгоор ажилласан, мөн сургуульд сонсогчоор суралцсан, цагдаагийн алба хаагчийн жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй хугацааг Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасанд хамааруулан уг алба хаасан 1 жилийг 1 жил 3 сартай дүйцүүлж цэргийн алба хаасан нийт хугацааг тооцно.

Иймд тус газрын 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/298 дугаар албан бичгийн 3.3-т заасныг цаашид баримтлахгүй болсныг анхаарах хэрэгтэй.

1.2.Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт “цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тооцно” гэж заасныг хэрэгжүүлэхдээ зөвхөн Цагдаагийн ерөнхий газрын даргын тодорхойлолт, мөн даргын гаргасан архивын лавлагааг үндэслэн тооцно. Харин цагдаагийн бусад албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцохдоо Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэс эсхүл тухайн алба хаагчийн алба хааж байсан цагдаагийн байгууллагын тооцон баталгаажуулсан тодорхойлолт, Цагдаагийн архивын лавлагааг үндэслэнэ.

1.3. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг “Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно” гэж өөрчлөн баталж 2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн мөрдөж байна.

Өөрөөр хэлбэл дотоодын цэргийн алба хаагчийн ажлын байр, албан тушаалыг харгалзахгүйгээр ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцон цэргийн тэтгэвэр тогтоох тул Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 01/825 дугаар албан бичгээр ирүүлсэн “Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь заалтад хамаарах албан тушаал”-д заасан албан тушаалын жагсаалтыг цаашид баримтлахгүй болсныг анхаарах хэрэгтэй.

Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд “Дотоодын цэргийн тухай хуулийн 36.3-т заасан хугацаа нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэнд хамаарахгүй”, мөн хуулийн 6 дугаар зүйлд “Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж, Дотоодын цэргийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Энэ хуулийг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж тус тус заасан тул 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө дотоодын цэргээс тэтгэвэр тогтоолгосон хүний цэргийн тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй, харин мөн өдөр буюу түүнээс хойш цэргийн тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч нь алба хаасан хугацаагаа нэмэгдүүлэн тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд Дотоодын цэргийн байгууллагад алба хаасан хугацааг шинэчлэн тооцсон тодорхойлолт, архивын лавлагааг үндэслэн тэтгэврийн хэмжээг нь өөрчлөн тогтоож, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан өөрчлөгдсөн тэтгэврийг олгоно.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2023 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн “Хамтран ажиллах тухай” 01/355 дугаар албан бичгээр шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цэргийн алба хаасан хугацааг хэрхэн тооцохтой холбоотой чиглэл ирүүлсэн байна. Үүнд:

2.1. Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 286 дугаар зүйлийн 286.7 дахь хэсгийн “тусгай байгууллагад” гэснийг “тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно” гэж өөрчилснийг хэрэгжүүлэхдээ “харьяа бусад байгууллага”-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа алба, төв, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, Улсын төсөвт болон Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, “Сүлд” биеийн тамир, спортын хороо, Үйлдвэр, аж ахуйн барилгын хэсэг, “Төр хур” амралт, нөхөн сэргээх сувилал, Согтууруулах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газарт ажиллаж байгаа алба хаагчдыг тус тус хамруулах чиглэлийг 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 1/1124 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Хуульд заасан “харьяа бусад байгууллага”-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Сургалтын төв, “Соёмбо” чуулгыг нэмж хамруулахаар чиглэл ирүүлсэн тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эдгээр байгууллагад алба хаасан 1 жилийг 1 жил 2 сараар тооцно.

2.2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно” гэж, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад “тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч ... офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох” гэж тус тус заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Тусгай ажиллагааны нэгжид ажилласан эсхүл тус байгууллагын алба хаагчийн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэтгэсэн хугацааг эдгээр хуулиудын дагуу дүйцүүлэн тооцохдоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тооцон баталгаажуулсан тодорхойлолт, архивын лавлагааг үндэслэнэ.

3. Шүүх шинжилгээний ерөнхий газраас 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 01/1415 дугаар албан бичгээр дараах чиглэлийг ирүүлсэн байна. Үүнд:

3.1. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар баталсан Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж байна.

Шүүх шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагч нь цагдаагийн дүрэмт хувцас, цол хэрэглэж, ялгах тэмдэгтэй байна.”, 58.3 дахь хэсэгт “Цагдаагийн цол олгох, дүрэмт хувцас хэрэглэх харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна”, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагч Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын болон бусад баталгаагаар хангагдана.”, 68.4 дэх хэсэгт “Шинжилгээний

байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй ажилласан шинжээч, мэргэжилтний төрийн албанд тухайн мэргэжлээрээ ажиллаж байсан хугацааг төрийн тусгай албанд ажилласан хугацаанд дүйцүүлж тооцно”, 71 дүгээр зүйлийн 71.12 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагчийн хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар, дэмжлэг үзүүлэх албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тус тус тооцно”, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагын захиалгаар суралцсан, шинжилгээний байгууллагын алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэрэг, цагдаагийн цолтойгоор ажилласан, мэргэжлийн сургуульд сонсогчоор суралцсан болон энэ хуульд заасан бусад хугацааг шинжилгээний байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцно” гэж тус тус заасныг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

3.1.1. Шинжилгээний байгууллагад шинжээч, мэргэжилтнээр сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй ажилласан алба хаагчийн төрийн албанд тухайн мэргэжлээрээ ажилласан хугацааг төрийн тусгай албанд ажилласан хугацаанд буюу цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцож, 1 жилийг 1 жил 4 сараар нэмэгдүүлэн алба хаасан хугацааг тооцож, цэргийн тэтгэвэр тогтооно. Энэ тохиолдолд Шүүх шинжилгээний байгууллагад алба хааснаар хугацааг тооцон баталгаажуулсан тодорхойлолт, архивын лавлагаа, ажилд авсан, чөлөөлсөн тушаал зэргийг үндэслэнэ.

3.1.2. Шинжилгээний байгууллагын хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар, дэмжлэг үзүүлэх албан тушаалд ажилласан, шинжилгээний байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцсан, шинжилгээний байгууллагын алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэрэг, цагдаагийн цолтойгоор ажилласан, мэргэжлийн сургуульд сонсогчоор суралцсан болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг шинжилгээний байгууллагад ажилласан хугацаанд оруулан 1 жилийг 1 жил 3 сараар тооцохдоо Шүүх шийнжилгээний байгууллагын алба хаасны хугацааг тооцон баталгаажуулсан тодорхойлолт, архивын лавлагааг үндэслэнэ.

Шүүх шинжилгээний байгууллын ирүүлсэн чиглэлд “Хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албаны албан тушаалын жагсаалт”-ыг хавсарган ирүүлсэн тул энэхүү жагсаалтад заасан албан тушаалд ажилласан хугацааг холбогдох хуулийн дагуу нэмэгдүүлэн тооцно.

3.1.3. Шүүх шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагч Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын болон бусад баталгаагаар хангагдана.” гэж заасан тул шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль болон Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан нийгэм, эдийн засгийн баталгаагаар нэгэн адил хангагдах юм.

Өөрөөр хэлбэл Шүүх шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон буюу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө

цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нь “хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар, дэмжлэг үзүүлэх албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар” нэмэгдүүлэн тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд Шүүх шинжилгээний байгууллагын алба хаасан хугацааг шинэчлэн тооцсон тодорхойлолт, архивын лавлагааг үндэслэн цэргийн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоож, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан өөрчлөгдсөн тэтгэврийг олгоно.

Түүнчлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн тэтгэвэр тогтоохдоо тухайн алба хаагчид цэргийн байгууллагаас гаргаж өгсөн цалингийн тодорхойлолтод тусгасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай тохирч байгаа тохиолдолд нийгмийн даатгалын байцаагчаар хянуулж, баталгаажуулах шаардлага тавихгүйгээр хүлээн авахыг цаашид анхаарна уу.

Иймд эдгээр чиглэл, зөвлөмжийн талаар ажил олгогч, даатгуулагч, иргэд, тэтгэвэр авагчдад мэдээлэл хүргэн, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллах нь зүйтэй.

Хавсралт 10 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,
Цахим шуудан: info@police.gov.mn,
Цахим хуудас: www.police.gov.mn

2023.02.15 № 04/МБ
танай _____-ны № _____-т

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ГАНЦЭЦЭГ ТАНАА**

Тодруулга, чиглэл хүргүүлэх тухай

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Нийгмийн даатгалын ерөнхий газартай "Хамтран ажиллах гэрээ" байгуулан ажиллаж байгаа бөгөөд Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор тус гэрээний хэрэгжилтийг хангах, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар дараах нэмэлт тодруулга, чиглэлийг хүргүүлж байна.

Нэг. Цагдаагийн албаны тухай хуулийн талаар

Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт "Цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан, цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цагдаагийн цолтойгоор ажилласан, цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан болон хуульд заасан бусад хугацааг цагдаагийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцно." гэж зохицуулсан.

Дээрх хуулийн зохицуулалтыг дор дурдсанаар тайлбарлан, мөн хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн "Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно." гэсэн зохицуулалтын дагуу нэмэгдүүлэн тооцож, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон буюу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх бүх хугацааг хамааруулан тооцохоор байна. Үүнд:

1.Цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан гэдэгт: Цагдаагийн байгууллагын захиалгаар, эрх бүхий албан тушаалтын шийдвэрээр гадаад, дотоодын академи, их, дээд сургууль, коллеж болон мэргэжил олгох, дээшлүүлэх курст суралцсан хугацааг;

2.Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цагдаагийн цолтойгоор ажилласан гэдэгт: Дотоод хэргийн их сургууль (одоогийн нэршлээр)-д томилох эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилогдож, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн цол олгогдон ажилласан хугацааг;

3.Цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан гэдэгт: Дотоод хэргийн их сургууль (одоогийн нэршлээр)-д сонсогчоор суралцсан хугацааг;

4.Хүүхэд асрах чөлөө авсан алба хаагчийн чөлөөтэй байх хугацаа нь төрийн тусгай алба хаасан хугацаанд тооцогддог тул энэ хугацаанд мөн нэмэгдэл тооцох.

Хоёр. Дотоодын цэргийн тухай хуулийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Дотоодын цэргийн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажилдаа хандах

хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, хуульд заасан баталгаагаар тэгш хангах зорилгоор "Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийг баталж, энэ оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт "Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно." гэж заасан бөгөөд тус байгууллагад ажиллаж байгаа бүх алба хаагчдын ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцохоор хуульчилж, Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд "Дотоодын цэргийн тухай хуулийн 36.3-т заасан хугацааг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэнд хамаарахгүй" гэж зохицуулсан.

Иймд дээрх зохицуулалтын хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш Дотоодын цэргийн байгууллагад ажиллаж байгаад цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэд хүсэлт гаргасан тохиолдолд тэтгэврийг нэмэгдүүлэн тогтоох.

Тодруулга, чиглэлийг хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 63 32, Факс: (976-11) 32 99 33,
Цахим шуудан: info@cd.gov.mn,
Цахим хуудас: www.cd.gov.mn

2023.02.09 № 01/355.

танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ГАНЦЭЦЭГ
ТАНАА**

Ц.Ганцэцэг

*Ашиг, дүүр чүүрэг
Зөвлөлийн даргид
Ушиг. 2023.02.14*

Төрийн албаны шударга ёс, эрх тэгш байх зарчмыг хангах, алба хаагчдын эрх зүйн байдлыг дээшлүүлэх, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажилдаа хандах хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, хуульд заасан баталгаагаар тэгш хангах зорилгоор Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан дараах хамтран ажиллах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 286 дугаар зүйлийн 286.7 дахь хэсэгт "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно." гэж тусгасан.

Хуульд заасан "харьяа бусад байгууллага"-д нэмж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Сургалтын төв, "Соёмбо" чуулгад ажиллаж байгаа алба хаагчид тус тус хамаарч, 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцох;


2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтад "Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүч хэрэгсэл оролцох"-оор тусгасан бөгөөд тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт "Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно" гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Тусгай ажиллагааны нэгжид ажиллаж байгаа алба хаагчид хууль хүчин төгөлдөр болсон 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс хойш 1 жил ажилласан хугацааг 1 жил 4 сараар тооцох;

3. Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад "Тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн отряд, застав болон тэдгээртэй адил нөхцөлд байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан 6 сар тутмыг 8 сард дүйцүүлэн тооцох"-оор тусгасны дагуу Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон

албан хаагчийн ажиллагаанд оролцсон 6 сар тутамд 2 сарын нэмэгдэл хугацааг тооцох;

Дээрх тооцооллоор тус байгууллагын алба хаагчдын тэтгэврийг тооцох талаар гаргасан санал, зөвлөмжийг хүлээн авч холбогдох харьяа байгууллагууддаа чиглэл хүргүүлэн хамтран ажиллахыг хүсье.

ДАРГА, ХУРАНДАА



О.АМАРСАНАА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Энхтайваны өргөн чөлөө, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 40 18, Факс: (976-51) 26 40 27,
Цахим шуудан: info@nfsa.gov.mn
Цахим хуудас: www.nfsa.gov.mn

2023.02.03 № 01/1415
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ГАНЦЭЦЭГ ТАНАА

Ц.Ганцэцэг

*Ашиг, гурч зүүрэг
Зөвлөлийн ахуй зүүрэг
Улаанбаатар 2023.03.03*

Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно” гэж зохицуулсан.

“Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт заагдсан албан тушаалд ажиллаж байгаа лабораторийн эрхлэгч, криминалистикийн шинжээч (мэргэшсэн, чиглэлийн болон ахлах), шинжээч эмч (мэргэшсэн, зөвлөх, чиглэлийн ахлах болон ахлах, гистологи, дүрс оношилгоо, нарийн мэргэжлийн, иммуногистохими), хими, биологи, ДНХ, физик, бактериологи, экологийн шинжээч зэрэг албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчдын тус байгууллагад ажилласан 1 жилийг 1 жил 2 сараар нэмэгдүүлэн тооцож, цэргийн байнгын тэтгэвэр тогтоон хуулийн хүрээнд хамтран ажиллаж ирлээ.

Дээрх хуулийн зохицуулалтад тус байгууллагын захиргаа, санхүү, аюулгүй байдал, хяналт шалгалт, дүн бүртгэл, мэдээллийн зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг алба хаагчид болон удирдах албан тушаалтнууд хамаардаггүй байсан.

Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажилдаа хандах хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, хуульд заасан баталгаагаар тэгш хангах зорилгоор “Шүүх шинжилгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Тус хуулийн 68 дугаар зүйлийн 68.4 дэх хэсэгт “Шинжилгээний байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй ажилласан шинжээч, мэргэжилтний төрийн албанд тухайн мэргэжлээрээ ажиллаж байсан хугацааг төрийн тусгай албанд ажилласан хугацаанд дүйцүүлж тооцно”, 71 дүгээр зүйлийн 71.12 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагчийн хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар, дэмжлэг үзүүлэх албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тус тус тооцно”, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагын захиалгаар суралцсан, шинжилгээний байгууллагын алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэрэг, цагдаагийн

1122200150

цолтойгоор ажилласан, мэргэжлийн сургуульд сонсогчоор суралцсан болон энэ хуульд заасан бусад хугацааг шинжилгээний байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцно” гэж тус тус хуульчилсан.

Мөн “Цагдаагийн албаны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нь цагдаагийн алба хаасан 1 жилийг 1 жил 3 сараар цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд цагдаагийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тооцсон тодорхойлолтыг тухайн цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгохын өмнө алба хааж байсан байгууллагын тооцон баталгаажуулсан тодорхойлолтыг үндэслэн “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийг үндэслэн тэтгэврийг өөрчлөн тогтоож, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан өөрчлөгдсөн тэтгэврийг олгож эхэлсэн.

“Шүүх шинжилгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагч нь цагдаагийн дүрэмт хувцас, цол хэрэглэж, ялгах тэмдэгтэй байна.”, 58.3 дахь хэсэгт “Цагдаагийн цол олгох, дүрэмт хувцас хэрэглэх харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна” гэж заасан.

Мөн хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “Шинжилгээний байгууллагын алба хаагч Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын болон бусад баталгаагаар хангагдана.” гэж эрх зүйн зохицуулалтыг тусгасан тул тус байгууллагын алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль болон Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан нийгэм, эдийн засгийн баталгаагаар нэгэн адил хангагдах юм.

Иймд хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Шинжилгээний байгууллагад шинжээч, мэргэжилтнээр сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй ажилласан алба хаагчийн төрийн албанд тухайн мэргэжлээрээ ажилласан хугацааг төрийн тусгай албанд ажилласан хугацаанд буюу цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцож, 1 жилийг 1 жил 4 сараар нэмэгдүүлэн алба хаасан хугацааг тооцож, цэргийн тэтгэвэр тогтоох;

Тухайлбал: Хүний их эмч тус байгууллагад тусгай мэргэжил бүхий шинжээч эмчээр сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй ажилласан тохиолдолд түүний өмнө нь улсын эмнэлэгт эмчээр ажилласан хугацааг төрийн тусгай албанд ажилласанд тооцон адилтган авч үзнэ.

2. Шинжилгээний байгууллагын хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар, дэмжлэг үзүүлэх албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн алба хаасан хугацааг тус тус тооцож, цэргийн тэтгэвэр тогтоох;

3. Шинжилгээний байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцсан, шинжилгээний байгууллагын алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэрэг, цагдаагийн цолтойгоор

ажилласан, мэргэжлийн сургуульд сонсогчоор суралцсан болон хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг шинжилгээний байгууллагад ажилласан хугацаанд оруулж 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн алба хаасан хугацааг тооцож, цэргийн тэтгэвэр тогтоох;

4. "Шүүх шинжилгээний тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон буюу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нь "хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар, дэмжлэг үзүүлэх албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар" нэмэгдүүлэн тооцуулахаар хүсэлт гаргасан тохиолдолд Шүүх шинжилгээний байгууллагын алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тооцсон тухай албан бичиг, тодорхойлолтыг үндэслэн тус байгууллагаас цэргийн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нийт ахмад ажилтны тэтгэврийн хэмжээг шинэчлэн тогтоох.


Шүүх шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллага хоорондын ажлыг уялдуулах, алба хаагчдад хуульд заасан баталгааг эдлүүлэх талаар гаргасан чиглэлийг хүлээн авч, Нийгмийн даатгалын байгууллагын аймаг, дүүрэг (нийслэл)-ийн салбар нэгжүүдэд хүргүүлж хамтран ажиллахыг Танаас хүсье.

Жич: "Хэргийн газрын үзлэгт оролцох, шинжилгээ хийх, лабораторийн нөхцөл, жижүүрийн албаны албан тушаалын жагсаалт", "Шүүх шинжилгээний ерөнхий газар болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд байгуулах гэрээ"-г хавсаргав.

Хавсралт 6. хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ж.БУЯНБАТ

Шүүх шинжилгээний ерөнхий газрын
2023 оны 2-дугаар сарын 05-ны өдрийн
01/... дугаартай албан бичгийн хавсралт
/4415

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН 71 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 71.12 ДАХЬ
ХЭСЭГТ ЗААСАН АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-ЫН ЖАГСААЛТ

№	1 жилийг 1 жил 4 сараар тооцох ажлын байр (албан тушаал)	
1	Хэргийн газрын үзлэгт оролцох:	<ul style="list-style-type: none"> -Хэргийн газрын үзлэгийн багийн чиглэлийн ахлах шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Аймгийн шүүх шинжилгээний хэлтэс, хэсгийн криминалистикийн ахлах шинжээч, криминалистикийн шинжээч; -Аймгийн шүүх шинжилгээний хэлтэс, хэсгийн ахлах шинжээч эмч, шинжээч эмч;
2	Шинжилгээ хийх:	<ul style="list-style-type: none"> -Инженер-техникийн шинжилгээний газар, хэлтэс, Байгалийн ухааны шинжилгээний газар, хэлтэс, Шүүх анагаах ухааны шинжилгээний газар, хэлтэс, Криминалистикийн шинжилгээний газар, хэлтэс, Эдийн засгийн шинжилгээний газар, хэлтэс болон Шүүх сэтгэцийн шинжилгээний тасаг, Шүүх эмнэлгийн шинжилгээний тасгийн дарга нар; -Цахим технологийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Инженер техникийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Хэргийн газрыг сэргээн дүрслэх чиглэл хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Автотехникийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Биологийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -ДНХ-ийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Химийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Физикийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Шүүх эмнэлгийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч эмч, ахлах шинжээч эмч, шинжээч эмч; -Шүүх сэтгэцийн шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч эмч, ахлах шинжээч эмч, шинжээч эмч; -Шүүх дүрс оношилгооны шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч эмч, ахлах шинжээч эмч, шинжээч эмч; -Чиглэлийн ахлах шинжээч; -Санхүү, бүртгэлийн мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч; -Хөрөнгийн үнэлгээний мэргэшсэн шинжээч, ахлах шинжээч, шинжээч;

		<p>-Цахим технологи, Инженер техник, Хэргийн газрыг сэргээн дүрслэх, Авто техникийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, ахлах шинжээч, шинжээч; -Хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний лабораторийн эрхлэгч, шинжээч; -Хүрээлэн буй орчны шинжилгээ хариуцсан ахлах шинжээч, шинжээч; -Хүрээлэн буй орчны үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, шинжээч; -Санхүү, бүртгэлийн шинжилгээний хэсгийн ахлах шинжээч, шинжээч; -Хөрөнгийн үнэлгээний хэсгийн ахлах шинжээч, шинжээч; -Гарын мөр, Мөр судлал, Бичиг баримт, Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх хэрэгслийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, ахлах шинжээч, шинжээч; -Ахлах сэтгэл зүйч эмч; -Сэтгэл зүйч эмч; -Полиграфын мэргэжилтэн; -Тархины бичлэгийн эмч; -Сэтгэл зүйч; -Аймгийн шүүх шинжилгээний хэлтэс, хэсгийн экологийн ахлах шинжээч, шинжээч;</p>
3	Лабораторийн нөхцөл:	<p>-ДНХ, хими, физик, биологийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, ахлах шинжээч, шинжээч; -Шүүх эмнэлгийн шинжилгээний тасгийн ахлах шинжээч эмч, шинжээч эмч; -Шүүх эд эсийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, ахлах шинжээч, шинжээч, иммуногистохимийн шинжээч; -Шүүх дүрс оношилгооны шинжилгээний лабораторийн ахлах шинжээч эмч, шинжээч эмч; -Шүүх бактериологийн шинжилгээний лабораторийн бактериологийн ахлах шинжээч, шинжээч; -Генетик мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн; -Мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн; -Гистологийн лаборант; -ДНХ-ийн лаборант; -Химийн лаборант; -Биологийн лаборант; -Лаборант; -Аймгийн шүүх шинжилгээний хэлтэс, хэсгийн лаборант; -Таниулах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн; -Бага эмч; -Рентген техникч;</p>
4	Жижүүрийн алба:	<p>-Шуурхай удирдлагын ахлах зохицуулагч, зохицуулагч; -Жижүүрийн цагдаа; -Жолооч; -Туслах ажилтан; -Гэрэл зураг боловсруулах лабораторийн ахлах лаборант, лаборант;</p>

1 жилийг 1 жил 3 сараар тооцох ажлын байр (албан тушаал)		
1	Дэмжлэг үзүүлэх:	1 жилийг 1 жил 4 сараар тооцох ажлын байр (албан тушаал)-аас бусад; (Дээрх жагсаалтад тусгагдаагүй бусад албан тушаал)

_____ оОо _____